НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН 2012 ОНЫ АЖЛЫН ҮР ДҮН, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН 2012 ОНЫ АЖЛЫН ҮР ДҮН, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2012 оны зорилт болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2009-2012 оны үйл ажилллагааны хөтөлбөрт соёл урлагийг хөгжүүлэхээр дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, Нийслэлээс 2012 оныг **"Иргэдийн оролцоо-өрхийн хөгжлийг дэмжих жил"** болгон зарласантай холбогдуулан Соёл урлагийн газар нь салбарын хэмжээнд **"Соёлтой иргэн-өрхийн хөгжил"** зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Эдгээр зорилтын хэрэгжилт, үйл ажиллагааны тайланг дараахи бүлэг, асуудлын хүрээнд товч танилцуулж байна.

- Соёл урлагийг хөгжүүлэхээр дэвшүүлсэн үндсэн зорилтын хэрэгжилт, үр дүн
- Соёл урлагийн олон талт үйл ажиллагааг зохион байгуулсан ажлын хэрэгжилт

НЭГ: СОЁЛ УРЛАГИЙГ ХӨГЖҮҮЛЭХЭЭР ДЭВШҮҮЛСЭН ҮНДСЭН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийслэлийн соёл урлагийн салбарыг хөгжүүлэхээр тусгасан 12 заалтыг 100%-ийн хэрэгжилттэйгээр биелүүллээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай Ерөнхий менежерийн байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгай захиалгат 5, нийт 33бүтээгдэхүүнийг гэрээний дагуу чанартай 100 хувь нийлүүллээ.

"Соёлтой иргэн-өрхийн хөгжил"зорилтын хүрээнд хийсэн ажил:

"Хүрээ соёл" аяныг бүх нийтийн хэрэг болгон зохион байгуулж, Нийслэлийн Засаг даргын орлогчоор аяны удирдамжийг батлуулан, нийслэлийн агентлаг, дүүрэг, аж ахуйн нэгж, байгууллагуудын хэмжээнд өрнүүлж, тус аяны явц, байдалд цаг тухайд нь үнэлэлт, дүгнэлт өгч ажиллалаа. Нийслэлийн дүүрэг, агентлагууд энэ аянд идэвх санаачилгатай оролцон үр бүтээлтэй ажил зохион

байгуулж, ажлаа дүгнэн тодорхой үр дүнд хүрснээ тайлан болон хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр олон нийтэд хүргэсэн байна.

Хүрээ соёл аянд:

1. Ус сувгийн удирдах газар
2. Нийслэийн Архивийн газар
3. Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар
4. Баянгол дүүргийн 113-р сургууль
5. Баянгол дүүргийн 21-р хороо
6. Баянгол дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл
7. Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний Удирдлагын төв
8. Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар
9. Сонгионхайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар
10. Сонгионхайрхан дүүргийн 4-р хороо
11. Сонгионхайрхан дүүргийн 113-р цэцэрлэг
12. Сонгионхайрхан дүүргийн 110-р цэцэрлэг
13. Сонгионхайрхан дүүргийн 65-р сургууль
14. Сонгионхайрхан дүүргийн 127-р цэцэрлэг
15. Нийслэлийн Улаанбаатар чуулга
16. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар
17. Нийслэлийн Барилга хот байгуулалт төлөвлөлтийн гаазр
18. Нийслэлийн Авто замын газар
19. Хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай төв
20. Үндэсний цэцэрлэгт хүрээлэн
21. Нийслэлийн Замын хөдөлгөөний удирдлагын төв зэрэг байгууллагууд идэвх санаачилгатай оролцож, ажлынхаа тайлан, холбогдох материалыг аяны дүгнэх ажлын хэсэгт ирүүлээд байна.

Тус аяны жилийн ажлын үр дүнг дүгнэж шалгаруулах нийслэлийн ажлын комиссыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2012 оны 10 дугаар сарын 08-ний өдрийн тушаалаар байгуулан ажиллууллаа.

Аяны удирдамжийг хэрэгжүүлж, бүтээлч ажил өрнүүлэн үр дүнтэй ажилласан шилдэг агентлаг, дүүрэг, хороо, байгууллага, шилдэг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагыг 1,2,3-р байр эзлүүлэн өргөмжлөл, 500.000-3.000.000 төгрөгийн мөнгөн шагнал олгох юм.

“Хүрээ соёл” аяны хүрээнд Нийслэл, дүүргүүдэд зохион байгуулагдсан зарим ажлаас:

- Аяны хүрээнд НЗДТГ, нийслэлийн холбогдох агентлагтай хамтран **“Хотын соёл”** асуудлаар зөвлөлдөх уулзалтыг нийслэлийн хэмжээнд 2012 оны 05 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан бөгөөд тус зөвлөлдөх уулзалтанд соёлын тулгамдсан асуудал цаашид хэрэгжүүлэхүйл ажиллагааны тухай эрдэмтэн судлаачид, мэргэжлийн ажилтангууд илтгэл тавьж хэлэцүүлэг хийлээ.

  Тус зөвлөлдөх уулзалтын илтгэл хэлэлцүүлгийн материалыг гарын авлага болгон эмхэтгэн дүүрэг, агентлаг, аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох ажилтан, албан хаагчдад хүргүүлж, зөвлөгөөний шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн. Зөвлөгөөнд соёл урлагийн байгууллагын удирдлагууд, холбогдох агентлагийн дарга, мэргэжилтэн нар оролцож, хүндэт зочноор Итали улсын Милан хотын Соёлын газрын дарга, Монголын Урлагийн зөвлөлийн гүйцэтгэх захирал оролцож үг хэлж, ажил, туршлагаа солилцлоо.
- **“Нийслэл хотын нээлттэй өдөрлөг**”-ийг Сүхбаатарын талбайд 2012.05.26-ны өдөр зохион байгуулж, урлагийн тоглолт, соёлын үйлчилгээг үзүүллээ. Өдөрлөгт 8000 гаруй иргэд хамрагдаж, өрх гэрийн соёл, эрүүл мэнд, нийгмийн даатгал, татвар, иргэний бүртгэл мэдээллийн асуудлаар зөвлөгөө, үйлчилгээ авсан байна.
- Нийслэл хотынхоо өнгө, үзэмж соёлыг дээшлүүлэхэд хүүхэд залуусын оролцоог сайжруулах асуудлаар эрдтэмтэн судлаачид, нийслэлийн уугуул иргэдтэй уулзалт ярилцлага зохион байгуулж, түүхэн газар, хөшөө, дурсгалтай танилцах аялалыг 6 дүүргийн 180 гаруй сурагчид, 100 гаруй цэцэрлэгийн насны хүүхдийг оролцуулан 2012 оны 04, 05 дугаар саруудад зохион байгуулав.
- НСУГ-аас дүүрэг, хороодод **“Соёлтой өрх, соёлч хамт олон**” шалгаруулах хөдөлгөөн өрнүүлэх ажлын зорилго, чиглэлийн асуудлаар Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн, Соёлын ордны дарга, захирал нарт тогтмол арга зүйн зөвлөгөө өгч, зохион байгуулж буй ажилтай нь танилцаж байлаа.

  Дээрхи ажлыг хамтран зохион байгуулан ажилласан зарим ажлыг танилцуулахад:

- Тус газар нь Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран хороо, өрхийн хэмжээнд “Тэнгэрлэг аав”, “Соёлтой өрх” аян зохион байгуулж, шилдэг 7 өрхийг шалгаруулж, 2,4,10-р хорооны 5 өрхийн тэргүүнийг “Тэнгэрлэг аав”-аар тодруулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж, соёлтой өрхийг нэмэгдүүлж, амьдрал туршлагыг нь дэлгэрүүлэх ажил зохион байгуулав.
- Нийслэлийн Соёл урлагийн газар, Баянзүрх дүүргийн Соёлын ордноос **“Гайхамшигт Монгол урлагийг бишрэн хүндэтгэх нь**” сэдэвт үндэсний урлагийг гэр бүл, хүүхэд, залууст өвлөн уламжлуулах, судлан дэлгэрүүлэхээр Соёл Урлагийн Их сургууль, Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын удирлага, эрдэмтэн багш нарын оролцоотой эрдэм шинжилгээний хурал, ардын урлагийг сурталчлах ажлыг зохион байгуулав. Уг арга хэмжээнд дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын соёлын асуудал хариуцсан мэргэжилтнүүд, Соёлын ордны захирал, дуу хөгжмийн багш, менежер, харъяа соёл урлагийн байгууллагын дарга, захирал болон ардын авъяастан, иргэд нийт 120 гаруй хүн оролцов.
- Нийслэлийн Соёл урлагийн газар,Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хан-Уул дүүргийн Соёлын ордноос **“Бид Хан-Уулын авъяастнууд” зорилтот төсөл** хэрэгжүүлэн хороодын ардын авъяастнуудын урлагийн наадам зохион байгууллаа. Энэ төслийн хүрээнд Хан-Уул дүүргийн соёлын өдрүүдийг 5-р сарын 14-19-ны өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хот, Шилэн гол аймагт хийлээ. Уг соёлын өдөрт нийт 100 хүний бүрэлдэхүүнтэй баг ажилласнаас урлагийн баг дангаараа 67 хүний бүрэлдэхүүнтэйгээр үндэсний урлаг, соёлоо толилуулаа.
- Багануур дүүргийн Соёлын ордноос **“Авъяаслаг гэр бүл**” цэнгүүн зохион байгуулж, гэр бүлийн хослон дуулаач, бяцхан авъяастан, шилдэг урлаачийг шалгаруулсан байна. Гэр бүлийн баярын цэнгүүнд 31 гэр бүл, 170 гаруй хүүхэд, иргэд авъяастан оролцжээ.
- Дүүргүүдийн Соёлын ордноос “Эрүүл амьдрах төв” ТББ-тай хамтран соёлтой өрх төлөвшүүлэх хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилгоор “Архигүй Монголын төлөө хамтдаа”, “Дам тамхидалт-эрүүл саруул гэр бүл”, “Хүүхэд-соёлтой өрх” соён гэгээрүүлэх уулзалт ярилцлага, урлаг соёлын ажил зохион байгуулснаар 320 өрх, 1960 гаруй иргэнийг хамруулсан байна. Энэ ажлууд нь сар тутам зохиогдож байлаа.

Нийслэлд байгаа хараа хяналтгүй хүүхдийн тоог бууруулах, гэр бүлд нь буцааж, нийгмийн ажлын олон талт үйлчилгээг хүргэх ажлыг сайжруулахаар Нийслэлийн Засаг даргын 2011 оны 879 дүгээр захирамжаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус газраас төлөөлөн ажиллаж, хараа хяналтгүй 157 хүүхэд, түүний эцэг, эхэд зөвлөгөө өглөө. Эдгээр хүүхдийг өөрсдийн сонирхол, авъяас чадварт нь түшиглэн авъяас хөгжүүлэх сургалт, соёлын үйлчилгээнд үе шаттай хамруулан иргэншүүлэх ажил зохион байгууллаа.

“Иргэдийн оролцоо-өрхийн хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд Олон улсын хүүхдийн урлагийн “Алтан гадас-2012” наадмыг Соёлын аялал жуулчлалын нийгэмлэг, Улаанбаатар хот дахь Оросын Шинжлэх ухаан соёлын төв, ОХУ-ын Улаан-Үүд хотын Боловсролын газартай хамтран 3-р сарын 26-27-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Нийслэл болон тус газраас дэвшүүлсэн “Иргэдийн оролцоо-өрхийн хөгжлийг дэмжих жил”, “Соёлтой иргэн-өрхийн хөгжил” зорилтын ажлын хүрээнд дээрхи ажлыг зохион байгуулсаны үр дүнд:

Иргэд, өрхийн хөгжлийг дэмжих соёл урлагийн ажлын цар хүрээ өргөжиж, ялангуяа нийслэлийн хэмжээнд иргэд, айл өрхийг соён гэгээрүүлэх, нийтийн соёлыг дээшлүүлэх ажлыг бүх хамт олон, аж ахуйн нэгж байгууллага бүр эрхэмлэн дээдэлж ажиллаж амьдрах ухаарал, гэгээрэлийг төрүүлсэн төдийгүй, энэ асуудлаар тодорхой үр бүтээлтэй ажил зохион байгуулагдлаа.

2012 ондсоёл урлагийн үйл ажиллагаа, соён гэгээрүүлэх 690 гаруй ажилд нийслэлийн 1.650.000 гаруй хүн хамрагдсан байна.

Иргэд, хүүхэд, залуусын авъяас хөгжүүлэх 28 сургалтанд 1620 хүн хамрагдаж, тэргүүний ардын авъяастан цол тэмдгээр 42, Соёлын тэргүүний ажилтан цолтэмдгээр 31 соёлын ажилтан, уран бүтээлчид шагнагдсан байна.

Нийслэлийн соёл урлагийн салбарын хэмжээнд шинэ ажлын байранд 12 хүн томилогдож, түр ажлын байраар 23 хүн хангагдсан байна.

Дээрхи ажлыг зохион байгуулахад салбарын хэмжээнд 20 гаруй сая төгрөгийн төсөв, санхүү зарцуулсан байна.

Соёл урлагийн үйл ажиллагааг чанартай, хариуцлагатай зохион байгуулахад удирдлага, эрх зүйн орчныг төлөвшүүлэх талаар хийсэн зарим ажил:

БСШУЯ-ны сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хамтын ажиллагааны "Санамж бичиг"-ийн хүрээнд дүүргүүдийн "**Соёлын төвийн үлгэрчилсэн дүрэм"-ийг** шинэчлэн боловсруулж, БСШУЯ-ны сайдын 2011 оны 83 дугаар тушаалаар дүүргүүдийн Соёлын төвүүдийг Соёлын ордон болгон өргөтгөн зохион байгуулж, НСУГ-ын даргын 2011 оны 24 дүгээр тушаалаар Соёлын ордны бүтэц, зохион байгуулалтыг баталж дээрхи эрх зүйн орчны хүрээнд дүүргүүдийн соёлын ордон 2012 онд шинэ зохион байгуулалтанд шилжин үйл ажиллагаа нь тогтмолжин ажиллаж байна.

МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 заалт, Үндэсний болон дэд хөтөлбөр 4, МУ-ын Засгийн газрын 8 тогтоол, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 12 заалт, Нийслэлийн эдийн засаг нийгмийн зорилтын 10 заалтын хэрэгжилтийг улирал, хагас, бүтэн жилээр гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлж, ажлаа дүгнүүлэв.

Соёл урлагийн газраас Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2013 оны зорилт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд соёл урлагийн салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөтэй уялдуулан 2013-2016 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний саналаа НЗДТГ-ын Хот төлөвлөлтийн хэлтэст гарган өглөө.

Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2013 оны зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн **Удирдлагын зөвлөлийн** хуралдаанаар 2013 онд соёл урлагийн салбараас хэлэлцүүлэх 6 асуудлыг төлөвлөн НЗДТГ-т хүргүүлж, хэлэлцэх асуудлын саналын төлөвлөгөөнд оруулаад байна.

Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2012 оны зорилтод соёл урлагийн салбарыг хөгжүүлэхээр тусгагдсан ажлын хүрээнд Нийслэлийн Зураг төслийн хүрээлэнгээс явуулсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага судалгаанд Нийслэлийн дүүргүүдэд шинээр баригдах соёл үйлчилгээний цогцолбор болон дүүргүүдэд баригдах соёлын орднуудын саналаа тусган ажиллалаа.

Нийслэлийн 2012 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд Баганаар дүүрэгт шинээр баригдах Соёлын ордны барилгын 2 тэрбум төгрөгийн төсвийг дүүргийн 2012 оны төсөвт суулгаж, зураг төслийн ажил хийгдэжд байна. 2012 оны 10 дугаар сарын 08-нд барилгын тендерийг дүүрэгт зарлаж "Сант хаан" ХХК тендерт шалгаран гэрээ байгуулж, дулааны шугам тавих ажил хийгдэж байна.

Баянзүрх дүүрэгт 500 суудал бүхий соёлын ордны барилга барихаар 4,8 тэрбум төгрөгийн санхүүжилтийн асуудал шийдэгдсэн бөгөөд барилгын тендерийг зарлаж “Намун дэвжих” ХХК тендерээр шалгарсан байна.

Баянгол дүүрэгт Тайвань улсын хамтын ажиллагааны хүрээнд Тайвань улсын хөрөнгө оруулалтаар Соёлын ордон барихаар гэрээ байгуулан зураг төсөл, газрын асуудлыг шийдээд байна.

Сонгинохайрхан дүүрэгт баригдах Соёлын ордны газрын асуудал шийдвэрлэгдсэн.

Дүүргүүдийн соёлын орднуудад шаардлагатай техник тоног төхөөрөмжийн зардлыг байгууллага бүрээр 2012 оны төсвийн урсгал зардалд тусган БСШУЯ-нд хүргүүлснээр нийт 7сая 200 мянган төгрөг батлагдан зарим хөрөнгө оруулалтыг хийсэн байна.

Мөн яам болон нийслэлийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөл, нийслэлд хандивлагчдын уулзалт зөвлөлгөөн, бусад хөрөнгө оруулагчбайгууллагуудад хандан дүүрэг, байгууллагуудын зүгээс төсөл боловсруулан өгч, шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдүүлсэн байна. Тухайлбал:Багахангай дүүргийнСоёлын ордон Засаг даргын нөөц хөрөнгөөр 1.2 сая төгрөгийн өртөг бүхий “Ямаха-650” даралтат хөгжим, “Тогтвортой амьжиргаа-2 төсөл”-ийн хүрээнд 16.0 сая төгрөгийн өртөг бүхий “Явуулын үйлчилгээний автомашин”-аар хангагдсан байна.

Баянзүрх дүүргийн Соёлын ордон, Сонгинохайрхан дүүргийн Жаргалант тосгоны Соёлын ордон албан хэрэгцээндээ 350,0 мянган төгрөгний үнэ бүхий тус бүр 1 принтерийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хангагдлаа.

Налайх дүүргийн Соёлын ордон жүжигчдийн өрөө, кассын өрөөг тохижуулах, үзэгчдийн танхимын гэрэлтүүлэг, гадна хашаа хайс,хамгаалалтыг будах, сэлбэх, өвөлжилтийн бэлтгэлийг хангаж, сантехник, дулааны шугам,хаалтыг сольж засварлах үйлчилгээнд нийт 1.245.700 төгрөгийн зардал гаргасан байна.

НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 03 дугаар тогтоолоор “Соёл урлагийг нийслэл болон Улаанбаатарын бүсийн хүрээнд 2020 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө”–г батлуулан харъяа Соёл урлагийн байгууллагуудын удирдлагуудад хэрэгжүүлэх ажлын зөвлөмж, чиглэл өгч дүүрэг, орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулав.

Мастер төлөвлөгөө гарсантай холбогдуулан байгууллагын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж ажиллалаа. “Миний бүтээсэн Улаанбаатар” ТББ-тай

хамтранхотын соёл, соён гэгээрүүлэх асуудлаар нийгэмд хандсан ажлуудыг зохион байгуулж, дүүргүүдэд 5 удаагийн сургалт, ярилцлага хийж. 560 гаруй хүнийг хамруулав.

МУИС-ийн Оюутны холбоотой хамтран “Оюутны оролцоо-Монгол улсын хөгжилд” чуулга уулзалтыг “Нийтийн тээврийн соёл, усны хэрэглээний асуудал”үндсэн хоёр сэдвийн хүрээнд зохион байгуулж чуулганаас гарсан санал санаачилгыг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хамтран ажиллаж байна.

Цаашид Соёл урлагийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх бодлогын зорилтуудын саналыг Нийслэлийн дунд хугацааны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулах төслийг хүргүүлсэн бөгөөд архи тамхи, мансуурлын эсрэг сэтгэлгээний соёлыг хүүхэд залуучууд, иргэдэд төлөвшүүлэхсаналыг 2013 оны Нийслэлийн эдийн засаг,нийгмийн зорилтонд тусгаж, зорилтот ажил зохион байгуулах бэлтгэлийг хангаж байна.

НСУГ-ын 2011 оны үйл ажиллагааны үр дүн, хяналт шинжилгээ, үнэлгээний тайлангнэгтгэн гаргаж,БСШУЯ болон НЗДТГ-ын ХШҮГ-аар дүгнүүлж, ажлын үр дүнгээр эхний 5 байранд шалгарч, **хангалттай** үнэлгээ авлаа.

Тус газрын харъяа соёл урлагийн байгууллагууд болон нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 13 соёлын ордон, 4 мэргэжлийн урлагийн байгууллага, 3 кино театр, 2 музей, 9 номын сан буюу нийт 31 байгууллагын 2011 оны статистик мэдээг Үндэсний статистикийн газраас баталсан “СУ-1”, “СУ-16” маягтуудын дагуу нэгтгэн БСШУЯ-ны Мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний газар болон Нийслэлийн Статистикийн хэлтэст бичгээр болон файлаар хянуулан соёл урлагийн салбарын статистик тайланд нэгтггэв.

Байгууллагын “Дотоод журам”-ыг Хөдөлмөрийн тухай хууль /1999 он/, Төрийн албаны тухай хууль /2002 он/, Авилгын эсрэг хууль /2006 он/, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм /МУЗГ-ын 2010 оны 228 дугаар тогтоол/ зэрэг эрх зүйн актуудын холбогдох заалтыг үндэслэн шинэчилж, хамт олны хурлаар хэлэлцэн, НСУГ-ын даргын 2012 оны 01/А тоот тушаалын дагуу мөрдөн ажиллаж байна.

НЗД-ын 2011 оны 56 дугаар захирамжаар тус газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоосоныг үндэслэн НСУГ-ын даргын 2012 оны 01/А дугаар тушаалаар тус газрын бүтэц орон тоо /11/, ажил үүргийн хуваарийг шинэчлэн, үүнээс төсөв, статистик, нягтлан бодох бүртгэл хариуцсан мэргэжилтэн, номын сан, мэдээлэл

технологи, гадаад харилцаа харилцаа хариуцсан мэргэжилтэн, архивын ажилтан-нярав гэсэн шинэ ажлын байрыг бий болголоо.

Нийслэлийн соёл урлагийн салбарыг хөгжүүлэх бодлого, үйл ажиллагаа, ажлын цар хүрээг харгалзан НСУГ-ын төрийн албан хаагч, мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг шинэчлэн баталж, үр дүнгийн гэрээг байгуулан хагас жилээр тайланг сонсож, НСУГ-ын даргын 2012 оны А/71 дүгээр тушаалаар "Үр дүнгийн гэрээг дүгнэх ажлын хэсэг" байгуулан ажиллуулж, газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн мэргэжилтнүүдийн 2012 оны ажлын үр дүнд үнэлэлт өглөө.

Нийслэлийн дүүргүүдийн ЗДТГ-ын НХ-ийн соёл,ТББ хариуцсан мэрэгжилтнүүдийн ажил үүргийн хуваарь, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн баталж, тухайн дүүргүүдийн ЗДТГ-т хүргүүлэн ажлыг нь хамтран дүгнэж байгаа нь ажлын уялдаа холбоог сайжруулах, төрийн албан хаагчийн ажлын хариуцлага, сахилга бат, гүйцэтгэлийг чанаржуулахад үр дүнгээ өгч байна.

НСУГ-ын дарга, тухайн дүүргийн Засаг дарга нар Багахангай, Багануур, Налайх, Баянзүрх, Хан-уул, Сонгинохайрхан дүүргийн Соёлын ордоны захирлуудтай гурвалсан гэрээ байгуулж, хамтын хариуцлагыг дээшлүүлэх зорилго тавьж, хууль, эрх зүйн хэм хэмжээнд удирдлага, зохион байгуулалтын ажлыг явуулах нөхцөл бололцоог бүрдүүлсэнээр дээрхи байгууллагуудын ажилд урд жилийнхээс ахиц дэвшил гарлаа.

Нийслэлийн соёл урлагийн салбарын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн, "Ажлаа танилцуулах өдөр"-ийг НСУГ-ын даргын баталсан журам, хуваарийн дагуу тогтмол хийж, шуурхай зөвлөгөөн 6 удаа, хуваарийн бус 4 удаа, ажлаа танилцуулах өдрийг 5 удаа зохион байгуулж, цаг үед нь үүрэг даалгаварын биелэлтийг дүгнэж байв.

Соёл урлагийн салбарын "Ажлаа танилцуулах өдөр"-ийг соёлын үйлчилгээний анхан шатны нэгжид төвлөрүүлэн зохион байгуулж,30.000 гаруй иргэдийг хамруулан соёл урлагийн үйл ажиллагааны нээлттэй өдөр явуулж, сэтгэл ханамжийн судалгаа авах, санал сэтгэгдлийг нь сонсон хариу өгч ажиллалаа.

НСУГ-аас **"Ажлаа танилцуулах өдөр"-**

ийг оны эхнээс хуваарийн дагуу УБ хотын музей, УБ хотын Төв номын сан, “Улаанбаатар” чуулга, “Тэнгис”, ”Өргөө” кино театр, Багануур, Баянзүрх дүүргийн Соёлын ордон дээр тусгай хөтөлбөрөөр зохион байгуулж, үзэгч, үйлчлүүлэгчддээ ажлаа танилцуулж, санал сэтгэгдлийг нь хүлээн авлаа.

БСШУ-ны сайдын 2010 оны 529 дугээр тушаалаар Хүннү гүрэн байгуулагдсаны 2220, Үндэсний эрх чөлөөний хувьсгал өрнөсний 100, Эзэн богд Чингис хаан мэндэлсэний 850, Ардын хувьсгалын 90 жилийн ойн угтаж хүн амын соёлын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэхээр сум, дүүргийн соёлын ордон, төвүүдийн дунд зарласан “Соёлын төв-чанартай үйлчилгээ” болзолт уралдааны шалгуур, үзүүлэлтийг /2011, 2012 оны ажлын үр дүнгээр/ биелүүлж, улсад Багануур дүүргийн соёлын ордон 1 дугээр байранд шалгарч ССАЖЯ-ны цом, 10 сая, төгрөг, 2 дугаар байранд Баянзүрх дүүргийн Соёлын ордон шалгарч цом, 5 сая төгрөг, 3 дугаар байранд Хан-уул дүүргийн Соёлын ордон шалгарч цом, 3 сая төгрөгөөр шагнагдсан бөгөөд нийслэлийн хэмжээнд Налайх,Багахангай,Сонгинохайрхан дүүргийн Соёлын ордон тус тус шалгарч НСУГ-ын өргөмжлөл тус бүр 1-2 сая төгрөгөөр шагнагдаж ажлаа дүгнүүллээ.

Соёл урлагийн салбарын хэмжээнд 35 / удаагийн урт, богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалтанд давхардсан тоогоор 460соёлын ажилтан хамрагдаад байна. Соёл урлагийн байгууллагын 50гаруй ажилтан, уран бүтээлчдийг гадаад орны соёлын хамтын ажиллагаатай 8 хотод туршлага солилцох, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулав.

Тус газрын соён гэгээрүүлэх асуудал хариуцсан мэргэжилтэнг БНСУ-ын Сөүл хотод “Соёлын бодлого /хотын соёл/” 10 өдрийн сургалтанд хамруулсан.

Төрийн албаны удирдлагын сургуулийн Нийгмийн удирдлагын гарагийн ангийн /2012-2014/ Засгийн газрын тэтгэлэгт сургалтанд тус газрын мэргэжилтэн М.Мөнхсайхан, ХУД-ийн Соёлын ордоны менежер Д.Отгонбаяр, Улаанбаатар хотын музейн эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяр нарыг тус тус суралцуулж байна.

НСУГ,дүүргүүдийн соёлын ордон, харъяа байгууллагуудын удирдах ажилтан, менежерүүдийг Удирдлагын академи, ССАЖЯ, БСШУЯ,СУХ, НЗДТГ-ын төлөвлөгөөт сургалтанд тогмол харуулж ажлын ур чадвар, мэргэжил арга зүйг нь дээшлүүллээ.

Тухайлбал:

№	Сургалтынагуулга	Сургалтыг	Он.сар.	Хамрагдсан

	чиглэл	хамтран зохион байгуулсан байгууллага	өдөр хэдэн хоног	хүний тоо
1	Аймаг, нийслэлийн ЗДТГ, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсрол, Соёлын газруудын соёлын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн сургалт	БСШУЯ, Соёл урлагийн хороо, НСУГ	3 сард 7 хоногийн сургалт	Нийслэлийн 9 дүүргийн мэргэжилтэн, СО-ны ордоны арга зүйчид 11
2	Аймаг, орон нутгийн Соёлын төвийн мэргэжил дээшлүүлэх сургалт	БСШУЯ, Соёл урлагийн хороо, НСУГ	5 -р сард 14 хоногийн сургалтанд	Нийслэлийн 6 дүүргийн Соёлын ордоны захирлууд
3	Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд тулгамдсан асуудлууд нэгдсэн сургалт	Нийслэлийн Архивын газар	4 -р сард 6-р сард	НСУГ, Соёлын ордон, харъяа байгууллагын дарга, захирал, бичиг хэрэг, архивын ажилтан нийт 32 хүн
4	Төрийн албаны зөвлөл, НЗДТГ-аас агентлаг, дүүргийн ЗДТГ-ын хүний нөөцийн мэргэжилтний нэгдсэн сургалт	ТАЗ,НЗДТГ	5-р сард	НСУГ-ын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн, байгууллагуу-дын 14 ажилтан
5	“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө,орлогын мэдүүлгийн маягтыг бөглөх, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам”,авилгаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх асуудал сургалт, мэдээлэл	Авилгатай тэмцэх газар	5-р сард	Харъяа байгууллагын удирдлага, төрийн албан хаагчид, нийт 52
6	“Соёл ба хөгжил	ССАЖЯ, СУИС,	11-р сард	НСУГ-ын дарга

	чуулган”-ны эрдэм шинжилгээний хурал	ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, МУЗ		
7	Бүтээлч үйлдвэрлэл, аялал жуулчлал хэлэлцүүлэг	ССАЖЯ, СУИС, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, МУЗ	11-р сард	НСУГ-ын нийтийн соёл, чөлөөт цагийн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
8	“Соёл ба хөгжил чуулган” Соёл ба боловсрол хэлэлцүүлэг	ССАЖЯ, СУИС, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, МУЗ	11 сарын 26	НСУГ-ын нийтийн соёл, чөлөөт цагийн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
9	“Шинэчлэлийн Засгийн газрын бодлого, соёл урлаг” Соёлын ажилтны сургалт, семинар	ССАЖЯ, СУИС, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, МУЗ	12 сарын 12	НСУГ болон харъяа байгууллагын удирдлага, төрийн албан хаагчид, дүүргийн мэргэжилтнүүд, нийт 30
10	“Соёл ба хөгжил” соёлын чуулган	ССАЖЯ, СУИС, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, МУЗ	12 сарын 13, 14	НСУГ болон харъяа байгууллагын захирлууд, нийт 10
11	“Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын шинэчлэлд хамтдаа” үндэсний чуулган	ХАХНХЯ, ХТҮГ	12 сарын 14, 15	НСУГ-ын нийтийн соёл, чөлөөт цагийн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн 1
12	“Хотын соёлын бодлого” сургалт	Seoul хотын хүний нөөцийн академи	5-р сард	НСУГ-ын хэвлэл мэдээлэл, соён гэгээрүүлэх асуудал хариуцсан мэргэжилтэн 1
13	“Оюутны оролцоо-Монгол улсын хөгжил” III чуулган	МУИС	12-р сард	НСУГ-ын хэвлэл мэдээлэл, соён гэгээрүүлэх асуудал хариуцсан мэргэжилтэн 2
14	Соёлын статистикийн сургалт	СУИС, ЮНЕСКО-ийн	4 сарын 16-18	НСУГ-ын төсөв, статистик,

		статистикын хүрээлэн		нягтлан бодох бүртгэл хариуцсан мэргэжилтэн, ня-бо, дарга-16
15	“Засгийн газрын худалдан авах ажиллагааны зохион байгуулалт” сургалт	МУИС	4 сарын 23-25	НСУГ-ын 2 мэргэжилтэн
16	Төсвийн тухай шинэ хуулийн сургалт	ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс	5-р сард	НСУГ-ын төсөв, статистик, нягтлан бодох бүртгэл хариуцсан мэргэжилтэн, ня-бо 12
17	Утга соёлын өв	ЮНЕСКО, Соёлын өвийн төв	11-р сард 5 хоног	Соёлын өв, музей, техник аппартур хариуцсан мэргэжилтэн 1
18	Албан хэрэг хөтлөлт, архивын нэгдсэн сургалт	Нийслэлийн Архивын газар	11-сарын 2,3	НСУГ-2,дүүргүүдийн соёлын ордон, УБ хотын номын сан, музей, чуулга, Соёлын төв өргөө бичиг хэрэг, архивын ажилтан -18 бүгд-20
19	ОУ-ын Архивын форум	Үндэсний Архивын газар	7-р сард 3 хоног	Даргын туслах, бичиг хэрэг, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн 1
20	Музейн үзмэрийн бүртгэн баримтжуулалт, “Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх нь”	Соёлын өвийн төв. БСШУЯ	7 хоног	Музейн ажилтнууд 15

НЗДТГ, Архивын газраас албан хэрэг, хөтлөлтийн ажлын стандарт, төрийн албан хаагчдын албан хэрэг, хөтлөлтийн мэдлэгийг дээшлүүлэх асуудлаар “Баримт бичгийн стандарт” 1 сарын аяны хүрээнд тодорхой ажил төлөвлөн ажиллаж, тус газрын 10 албан хаагч баримт бичгийн стандартын сорилын шалгалтанд голч үнэлгээгээр 85.8 оноо буюу “В” үнэлгээ авлаа.

Мөн харъяа байгууллагын бичиг хэрэг, архивын 12 ажилтан, тус газрын 10 ажилтнаас өөрсдөө бие даан албан хэрэг хөтлөлтийн мэдлэгийн асуудлаар 2 дахь шалгалтыг авч дүн мэдээг НАГ хүргүүлсэн бөгөөд цаашид анхаарах асуудлаар зөвлөгөө, ярилцлага хийлээ.

2012 онд соёл урлагийн салбарын нийт ажиллагсад100% ямар нэг сургалтанд хамрагдаж, мэргэжил, ур чадвараа дээшлүүлсэн байна.

Салбарын ажилтнуудыг цаг үеийн мэдээллээр хангах ажлыг тогтмолжуулж 8 удаагийн мэдээллийн цагаар 456 ажилтан, ажиллагсдыг хамруулан Удирдлагын академи, Төрийн албаны зөвлөл, НЗДТГ, Нийслэлийн Архивын газар, Авлигатай тэмцэх газар зэрэг байгууллагуудын багш, эрдэмтэд, мэргэжилтнүүдээр сургалт, мэдээлэл хийлгэлээ.

НИТХ-ын 2/08 дугаар тогтоол, “Автозамын хэт ачааллаас урьдчилан сэргиийлэх зарим арга хэмжээг хэрэгжүүлэх тухай” НЗД-ын 2012 оны А/532 дугаар захирамж, НЗД-ын 2012 оны 03 дугаар албан даалгаварыг НСУГ-ын албан хаагч, харъяа соёл урлагийн байгууллагын дарга захирал нарт танилцуулан, үүрэг даалгавар өгч, дээрхи шийдвэрийн биелэлтэд тогтмол хяналт тавьж ажиллаж байлаа.

ХОЁР: ХҮН АМД ҮЗҮҮЛЭХСОЁЛ УРЛАГИЙН ОЛОН ТАЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ

2012 онд Нийслэл, дүүргийн соёл урлагийн байгууллагууд соёл урлагийн үйлчилгээний болон хүүхэд, залуусын авъяасыг хөгжүүлэх сургалт, уран бүтээлийн нэгдсэн хөтөлбөр гарган ажиллаж, хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар хүртээмжинд ахиц гаргасанаар иргэдийн талархалыг хүлээж, үйлчүүлэгчдийн сэтгэл ханамж өндөр байлаа.

11-р сард явуулсан судалгаанд хамрагдсан 460 хүний 86,2% нь “зохиогдож байгаа соёлын үйлчилгээ нь урьд жилүүдийнхээс бидний эрэлт хэрэгцээнд илүү нийцэж байгаа”, 12.6% нь ”дунд зэрэг”, 1.2% нь “соёлын үйлчилгээний зарим арга хэмжээ агуулга, хэлбэрийг өөрчлөх нь зүйтэй” гэсэн үнэлгээ өгчээ.

- Номын сан, соёлын ордон, Улаанбаатар чуулга, музейн үйлчилгээний чанар, байдлын асуудлаар тухайн байгууллага дээр 2 удаагийн сэтгэл

ханамжийн судалгаа авч түүний мөрөөр ажил зохион байгуулж, энэ ажил тогтмолжоод байна.

- Нийслэл, дүүргийн хэмжээнд авъяас хөгжүүлэх 28 төрлийн /үндэсний болон цэнгээнт бүжиг, драм, зураг, яруу найраг, морин хуур, уртын дуу, хөөмий, бий биелгээ, эстрад хөгжим, даралтад хөгжим г.м/ сургалтанд нийт 3820 хүүхэд, залуус, ардын авъястнууд суралцаж байгаа бөгөөд ардын болон орчин үеийн урлагийн 26 хамтлаг өөрийн дуу, хуур, авъяас билгээ сонирхуулан дүүрэг, хороодынхоо иргэддээ үйлчилжээ.

"Төрийн хан хуур" залсны 20 жилийн ойг тохиолдуулан Морин хуурын төв, Аргасун мюзик ХХК-ний санаачилга, БСШУЯ, НСУГ-ын дэмжлэгтэйгээр "Ширэн цартай морин хуураар тоглогчдын анхдугаар уралдаан"-ыг амжилттай зохион байгуулав. Тус уралдаанд Хөгжим бүжгийн коллеж, СУИС, Монголын Хүүхдийн ордон, Орхон аймгийн нийт 200 морин хуурч оролцож, авъяас билгээ сорьсоноос гранпри шагналаар СУИС-ийн оюутан П.Мөнхжин, тэргүүн байранд ХБК-ийн оюутан Б.Санжаажав болон дэд, гутгаар, шагналт, шүүгчдийн шагналыг СУИС, МХО-ны оюутан, сурагчид тус тус хүртлээ.

"Морин хуур, уртын дуу", "Монгол бий биелгээ", "Монгол хөөмий" зэрэг дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Морин хуурчдын Олон улсын 3 дугаар наадмыг Дэлхийн морин хуурчдын холбоо, Монголын морин хуурын төвтэй хамтран зохион байгуулав. Энэ наадамд Герман, Хятад, Солонгос, Америк, Буриад, Япон зэрэг 7 орны 200 гаруй морин хуурчид оролцов.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр НИТХ-ын тогтоолоор нийслэлийн дэд хөтөлбөрийг батлуулан доорх ажлуудыг зохион байгуулан ажиллав.

"Морин хуур, уртын дуу", "Монголын уламжлалт бий биелгээ", "Монгол хөөмий"

№	Үзүүлэлт	Дэд хөтөлбөрүүд			
Хөтөлбөрийн нэр		Нийт зарцуулсан хөрөнгө	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Тухайн жилд зарцуулсан хөрөнгө	Хөтөлбөр хэрэгжсэнээс хойш зарцуулсан хөрөнгө
А	**1**	**2**	**3**	**4**	**5**
1.	"Морин хуур, уртын дуу"	3.450.000	100%	3.450.000 /Нийслэ-	51.950.000₮ /нийслэлийн

	НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2005 оны 258 дугаар тогтоол			лийн төсөл хөтөлбө-рийн зардлаас/	хөрөнгөөр/
2.	“Монгол хөөмий” НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2008 оны 65 дугаар тогтоол	2.550.000	100%	2.550.000 /Нийслэ-лийн төсөл хөтөлбө-рийн зардлаас/	21.050.000₮ /нийслэлийн хөрөнгөөр/
3.	“Монголын уламжлалт бий биелгээ” НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 159 дүгээр тогтоол		100%		6.900.000₮ /нийслэлийн хөрөнгөөр/
4.	“Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах тухай” МУЗГ-ын 2007.11.21-ны 303 дугаар тогтоол	7.134.000	100%	7.134.000 /Нийслэ-лийн Засаг даргын захирам-жаар/	
Нийт дүн:			**13.134.000**		**79.900.000**

“Морин хуур уртын дуу” хөтөлбөрийн хүрээнд:

Нийслэлийн хэмжээнд морин хуурч, морин хуур урлаач, уртын дуучдын нэгдсэн судалгааг гаргаж нэгтгэв.

Баянзүрх дүүргийн Соёлын ордон, СУИС-тай хамтран “Морин хуур, Уртын дуу”, “Монгол Хөөмий”, “Бий биелгээ” хөтөлбөрийн хүрээнд **“Гайхамшигт монгол урлагийг бишрэн хүндэтгэх нь”** сэдэвт онол арга зүйн сургалт, хурал, ардын урлагийн тоглолтыг 2012 оны 3 дугаар сарын 27-нд зохион байгууллаа.

“Морин хуур уртын дуу”, “Монгол хөөмэй”, “Бий биелэгээ” дэд хөтөлбөрүүдийг ЕБС, СӨБ-ийн дуу хөгжмийн багш нар, ахмад ардын авьяастнууд, хүүхэд залуучуудад ардын үндэсний уламжлалт урлагаа бахархан дээдлэх, тэдний гоо сайхны хүмүүжлийг дээшлүүлэх, СУИС-ийн багш эрдэмтэн, мэргэжлийн уртын дууч, морин хуурчид, биелээчид, хөөмэйчдээс суралцах, хамтран ажиллах талаар санал солилцож зохион байгуулав.

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Төрийн хан хуур залсны 20 жилийн ойг угтаж үндэсний уламжлалт хөгжмийн өв болох ширэн цартай хуурын хэв маяг, хөг аялгууг хадгалах, өвлүүлэх, хөгжүүлэх, сурталчлах, мэргэжлийн сургалттай сургуулиудын сургалтын чанар болон ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Ширэн цартай хуур”-ын Улсын анхдугаар уралдааныг мэргэжлийн сургуулиудын дунд 2012 оны 4 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд зохион байгуулав. Уралдаанд нийт 28 хуурчид оролцсон бөгөөд уралдааны шагналын сан, бэлтгэл ажлын зардалд 3.000.000 төгрөг зарцуулав. Уралдааныг зохион байгуулах хорооноос уг уралдааныг 2 жил тутамд зохион байгуулж байхаар тогтлоо.

“Хууранд мөнхөрсөн аялгуу” 3 үеийн уртын дуучдын уралдааныг нийслэлийн хэмжээнд 5 дахь удаагаа 12 дугаар сарын 5-нд Налайх дүүргийн Соёлын ордонд зохион байгуулав.

Уралдаанд нийслэлийн 9 дүүргийн ардын авъяастнууд болон СУИС, ХБК-ийн бэлтгэл, 1-р курсийн нийт 10-75 насны 70 гаруй уртын дуучид оролцож, өсвөр нас, насанд хүрэгсэд, ахмад нас гэсэн 3 ангиллаар явагдлаа.

Энэ жилийн уралдаанд оролцогсодын тоо өсч ур чадвар, ялангуяа Налайх болон Багахангай дүүргийн соёлын ордны суралцагч хүүхдүүдийн ур чадвар ихээхэн өссөн байна гэж мэргэжлийн хүмүүс дүгнэлээ. Шүүгчдийн бүрэлдэхүүн уралдааны үр дүнгийн талаар оролцогчдод мэргэжил, арга зүйн зөвлөмж өгөв.

Уралдааны явцад ахмад уртын дуучид, туульч Б.Баярмагнай болон ардын авъяастнууд дуулж хуурдаж удирдамжинд заагдсан мартагдсан бөгөөд заавал дуулах дууг дуулж сонирхуулав.

Монгол ардын уртын дууг хүүхэд залуус сурах сонирхолтой болсноор хичээлд хамрагсдын тоо нэмэгдэж буй нь дэд хөтөлбөр амжилттай хэрэгжиж байгаагийн нэгэн нотолгоо болж байна. “Хууранд мөнхөрсөн аялгуу” уралдааныг зохион байгуулахад 450.000 төгрөгийн дэмжлэг үзүүлж хамтран зохион байгууллаа.

"Монгол хөөмий"хөтөлбөрийн хүрээнд:

"Монгол хөөмий" хөтөлбөрийг дүүрэг, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Дүүргүүдийн ардын авъяастнуудын дунд хөөмэйн төрлөөр анхан шатны болон сургагч багшийн сургалт явуулж, 10 хүнд сертификат олголоо.

Баянзүрх, Багануур, Жаргалант, Налайх, Багахангай дүүргийн соёлын орднуудад хөөмий сургалтанд нийт 26 хүн хамрагдаж ур чадавраа хөгжүүлж байна.

СУИС-ийн багш Д.Алтанчимэгийн уран бүтээлийн тоглолтонд дэмжлэг үзүүлсэн бөгөөд уг тоглолтонд хөөмийч 8 шавь нь оролцож авъяас билгээ сонирхуулж, туршлагаа солилцоо.

БСШУЯ, ЮНЕСКО, Соёлын өвийн төвтэй хамтран монгол хөөмий, монгол гар урлал, морин хуур хөгжмийн уламжлалт хийц, хэв маяг болон монгол ардын уртын дууны урын сан, дуулах арга барилыг язгуур хэв шинжээр нь өвлөн уламжлуулах, үндэстэн ястны бий биелгээг язгуур хэв шинжээр нь өвлөн хамгаалж хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн нийслэлийн 35 уран бүтээлч, ардын авъяастныг "Монголын билиг авъяастны улсын жагсаалт"-д бүртгэж БАТЛАМЖ гардуулж, мөнгөн шагнал олгов.

Нийслэлийн 9 дүүргийн ардын авъяастнуудын дунд "Хөөмэйн уянга" уралдааныг уламжлал болгон зохион байгуулсанаар Баянгол дүүргийн хөөмийч Т.Билгүүн 2010 онд зохиогдсон АУИН-ын алтан медаль, нийслэлд зохиогдсон "Хөөмэйн уянга-2011" уралдааны 3-р байр, 2012 онд ОХУ-д зохиогдсон хөөмийчдийн олон улсын уралдааны шагналыг тус тус хүртлээ.

Тус газрын санаачлагаар Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулдаг "Хөөмийгөөр уянгалсан хорвоо" хөөмийчдийн уралдааныг 2012 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Нийслэлийн хэмжээнд зохион байгуулж СУИС-ийн оюутнууд, дүүргүүдийн ардын авъяастнууд зэрэг 30 гаруй хөөмийчид уралдаанд оролцлоо.

Уралдаан өсвөр, насанд хүрэгсэд гэсэн 2 үе шаттайгаар явагдаж байр эзлүүлж шагнаж урамшуулав.

Урлагийн төрөл жанруудаас хөөмэй нь хувь хүнээс авъяас, хүсэл сонирхол, хөдөлмөр, тэсвэр тэвчээр шаарддаг урлаг тул анхнаас нь зөв сургаж хичээллүүлэх

шаардлагатай гэж шүүгчдийн бүрэлдэхүүн уралдаанд оролцогсдод зөвлөгөө өгөв. Уралдаанд нийт 550.000 төгрөгийн дэмжлэг үзүүллээ.

"Монголын уламжлалт бий биелгээ"хөтөлбөрийн хүрээнд:

Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд бие биелээчдийн нэгдсэн судалгааг гаргав.

"Бий биелгээ" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор дүүргүүдийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн болон харъяа газруудын дарга, захирал менежерүүдэд ажлын чиглэл, арга зүйн зөвлөмж өгөв.

"Монгол урлагийг бишрэн хүндэтгэх нь" сэдвээр онол, арга зүйн лекц концертыг Баянзүрх дүүргийн Соёлын ордон, СУИС-тай хамтран зохион байгуулав. Уг арга хэмжээнд СУИС-ийн Уртын дууны танхим, Ардын хөгжмийн танхим, Хөгжмийн онолын танхим, Бүжгийн заах арга зүйн танхимын багш, оюутнууд оролцож мэргэжлийн урлагийн тоглолт үзүүлэв.

Нийслэлийн дүүргүүдийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн, соёлын ордны захирал, менежер, морин хуур, уртын дууны болон бүжгийн багш нар, ЕБС-ийн дуу хөгжмийн багш нар хамрагдав.

Тус газрын дэмжлэгтэйгээр Сонгинохайрхан дүүргийн Ерөнхий боловсролын 36 дугаар сургуульд 90 гаруй хүүхдэд монголын уламжлалт бий биелгээний сургалт явуулж багшаар нь СХД-ийн иргэн Соёлын өв тээгч, бий биелээч Б.Баяртай ажиллаж байна.Дүүргүүдийн соёлын орднуудад бүжгийн сургалт тогтмолжиж 200 гаруй хүүхэд хичээллэж байна.

1912 онд Их хүрээг Богд хааны лүндэнгээр "Нийслэл хүрээ" хэмээн нэрлэсний 100 жилийн ойн хүрээнд Нийслэлийн Төр захиргааны байгууллагаас "Хүрээ соёл" аяныг өрнүүлж, шилдэг хороо, шилдэг төрийн бус, хувийн хэвшлийн болон хэвлэл мэдээллийн байгууллага шалгаруулах уралдааныг зохион байгуулсан бөгөөд ЗДТГ-ын даргын тушаалаар байгуулагдсан комисс аяны ажлыг дүгнэх юм.

"Хүрээ соёл" аяны хүрээнд иргэд, нийслэлчүүддээ зориулан дараахи ажлыг зохион байгуулав.

"ХҮРЭЭ СОЁЛ" сэдэвт эссе бичлэгийн уралдаан

Монгол улсын нийслэлийг 1912 онд Богд хааны лүндэнгээр "Нийслэл хүрээ" болгон нэрлэсний 100 жилийн ойн ажлын хүрээнд Улаанбаатар хотын түүхэн хөгжил, өв уламжлалыг оюутан залуучуудад таниулах,нийслэл хотоороо бахархах, эх оронч, соёлтой

иргэн болж төлөвшүүлэх, оюутан залуучуудын чөлөөт цагийг нь зөв боловсон өнгөрүүлэх, нийгэмд өөрсдийн байр суурьиа илэрхийлэх чадварыг нь хөгжүүлэх зорилгоор их, дээд сургуулиудын оюутан залуучуудын дунд "Хүрээ соёл" сэдэвт эссе бичлэгийн уралдааныг 2012 оны 1 дүгээр сарын 24-ны өдрөөс 2 дугаар сарын 04 ныг дуустал бүртгэж 2 дугаар сарын 07-нд дүнгээ гаргалаа. Эссэ бичлэгийн уралдааныг Чингэс хаан дээд сургуулийн захирал, доктор, профессор Х.Лхагвасүрэн, доктор, профессор О.Сүхбаатар, доктор С.Ичинноров, Ч.Батжаргал, МУБИС-ын багш, доктор О.Мөнхжаргал нарын бүрэлдэхүүнтэйгээр шүүн явуулав. Уралдаанд 16 эссег шалгаруулж эхний 5 байрыг эзлүүллээ.



Нэгдүгээр байранд: ЭМШУИС-ийн АИС-ын 123-р ангийн оюутанА.Хонгорзул

Хоёрдугаар байранд: МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургуулийнОлон улсын сэтгүүлчийн 3-р курсын оюутанБ.Баярбаясгалан

Гуравдугаар байранд: МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургуулийн Түүхийн 4-р курсын оюутан С.Сэрдамба

Тусгай байранд: Монгол улсын их сургуулийн Улаанбаатарсургуулийн Түүх-аялал жуулчлалын 4-р курсыноюутан Н.Манлайбаатар, Улаанбаатар-эрдэм оюу дээд сургуулийн Олон улсын харилцааны 4-р курсыноюутан Б.Золжаргал нар тус тус ээлж амжилт гаргав.

“НИЙСЛЭЛ ХҮРЭЭ 100 ЖИЛ”сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэн

Халх монголын улс төр, эдийн засаг, шашин, соёлын төв Их хүрээг Олноо Өргөгдсөн Богд Хаант Монгол Улсын “Нийслэл хүрээ”-гээр өргөмжилсний буюу өнөөгийн Улаанбаатар хот түүхэндээ анх удаа Монгол Улсын нийслэл хот болсны түүхт 100 жилийн ойд зориулсан “Нийслэл хүрээ 100 жил” сэдэвт гэрэл зургийн

үзэсгэлэнг олны хүртээл болгож Улаанбаатар хотын музейд зохион байгуулаа.

Тус гэрэл зургийн үзэсгэлэнгийн ерөнхий зохион байгуулагчаар Улаанбаатар хотын музей, хамтран зохион байгуулагчаар Нийслэлийн засаг даргын тамгын газар,

Архивын ерөнхий газар, Нийслэлийн Соёл, урлагийн газар, Гамма агентлаг оролцлоо.

1912 онд Их хүрээ хот Монгол Улсын нийслэл болсноос хойш тус улсын улс төр, нийгэм, соёл, боловсрол, эдийн засгийн амьдралд онцгой үүрэг гүйцэтгэж ирсэн бөгөөд эдгээр өөрчлөлт, шинэчлэлт, бүтээн байгуулалтын түүхэн агшнуудыг гэрэл зургаар харуулсан нь онцлог байв.Үзэсгэлэнд 1912-2012 оны хооронд нийслэл хотод өрнөсөн түүхэн үйл явдал болон нийслэл хотын өнгө төрх, дотоод амьдралыг харуулсан 100 орчим гэрэл зураг тавигдснаас гадна хотын түүхэн үйл явдлыг гэрчлэх сонирхолтой баримт бичиг, уран зураг, үзмэр, эд өлгийн зүйлс дэлгэгдсэн. Тухайлбал, XX зууны эхэн үеийн хүрээний урчуудын урласан ахуйн эд өлгийн зүйлс, Их хүрээг 1912 оны 2-р сард Нийслэл хүрээ хэмээн өргөмжилсөн Богдын лүндэн, 1914-1915 оны Нийслэл хүрээний байдлыг харуулсан “Нийслэл хүрээ” уран зураг, 1929 онд хотод анхны нийтийн тээврийн үйлчилгээг явуулах хурлын шийдвэр, Х.Чойлбалсан хотын харъяат болохыг хүссэн өргөдөл, Х.Чойбалсанг хотын харъяат болохыг зөвшөөрсөн шийдвэр, Улаанбаатар хотын анхны дарга Моононгийн Баярын хэрэглэж байсан хотын захиргааны анхны монгол бичгийн машин, гавъяат сийлбэрчин С.Сэнгээгийн “Түүхт Улаанбаатар” зааны соёон сийлбэр зэрэг олон сонирхолтой баримт, эд өлгийн зүйлс тавигдсан.

Нийслэл хүрээ 100 жилийн ойн хүрээнд **“Хүрээ гангачуул” сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэнгээр** нийт 518 хүн үзэж, 9 хэвлэл мэдээллийн хэрэгслээр;

Монголын Шог зургийн галерейтэй хамтран зохион байгуулсан **“Монголын шог зургийн түүх”**үзэсгэлэнд монголын анхны хошин шогийн хэвлэл Хүмүүжил жигшил, Матар, Тоншуул сэтгүүлүүдээс гадна монголын нэртэй хошин шогийн бүтээлүүд тавигдсан. Тус үзэсгэлэнг нийт 493 хүн үзэж, 12 хэвлэл мэдээллийн хэрэгслээр; **“Мартагдсан аялгуу буюу хойд Солонгосын тэмдэглэл”** сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэнг 366 хүн үзэж, 5 хэвлэл мэдээллийн хэрэгсэл;**“Амьдралын өнгө-2” сэдэвт эмэгтэй гэрэл зурагчдын үзэсгэлэн**д таван эмэгтэй гэрэл зурагчид өөрсдийн бүтээлүүдээ дэлгэн тавьсан бөгөөд үзэсгэлэнг нийт 405 хүн үзэж, 24 хэвлэл мэдээллийн хэрэгслээр;**“Зуун дамнасан зургууд”** сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэнг 290 хүн, 28 хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр;**“Хотын хүний зураг”** сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэнг 351 хүн үзэж, 22 хэвлэл мэдээллээр нийтэд тус тус сурталчилсан. Дээрх 7 гэрэл зургийн

үзэсгэлэнг нийт 5783 хүн үзэж, давхардсан тоогоор 117 хэвлэл мэдээллийн хэрэгслээр тус тус сурталчилсан байна.“Нийслэл хүрээ 100 жил” гэрэл зургийн үзэсгэлэн 2012 оны 2-р сарын 6-наас 12-ны өдрүүдэд нийслэлчүүддээ сонирхуулсан билээ.

“НИЙСЛЭЛ ХҮРЭЭ-100 ЖИЛ” архивын баримт бичиг, гэрэл зураг, эд өлгийн зүйлсийн үзэсгэлэн

2012 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Үндэсний музейд нээлтээ хийлээ. Монгол улсын үндэсний төв архивын сан хөмрөгөөс Их хүрээг Нийслэл Хүрээ хэмээн нэрлэсэн Богд хаантаны Зарлиг, Нийслэл хүрээнд Монгол улсын төрийн тугийг залах тухай айлтгал, буулгасан зарлиг, Монгол улсын анхдугаар их хурлаас Нийслэл хүрээг Улаанбаатар хот гэж нэрийдэхээр тогтсон тогтоол зэрэг баримт бичгүүд, Нийслэл хүрээнд байсан Монгол улсын төрийн яамдын байр, төрийн шар орд, Мэгжиджанрайсаг сүм, Чойжин ламын сүм, Дамбадаржаалин хийд зэрэг төрийн болон шашны байгууллагуудын гэрэл зургууд багтсан байна.

Нийслэлийн Архивын газрын сан хөмрөгөөс Хотын захиргааны түр дүрэм, Хотын захиргааны дүрэм, Олон хороодын дагаж явах дүрэм зэрэг баримт бичгүүд, Монголын Үндэсний музейн сан хөмрөгөөс Өндөр гэгээн Занабазарын хөрөг зураг, түүний эдэлж хэрэглэж байсан бурхны хэв, суврага, завъяа, Наран гэрэлт түмэн наст Богд хаантаны хувийн цуглуулгаас шүншигтэй мөнгөн заан, мөнгөн амсартай халтар манан гүц, лааны суурь мөн Нийслэл хүрээний сүм хийдүүдэд болон Хүрээ айлын эдэлж хэрэглэж байсан эд өлгийн зүйл зэрэг олон сонирхолтой үзмэрүүд тавигдсан.

“НИЙСЛЭЛ ХҮРЭЭ 100 ЖИЛ” хүндэтгэлийн концерт

2012.02.07-ны өдөр Соёлын төв өргөөнд зохион байгуулсан. Нийслэлийн Улаанбаатар чуулгынхан өөрсдийн уран бүтээлээ нийслэлийн үе үеийн удирдлагууд, нийслэлийн төр захиргааны байгууллагын ажилтан албан хаагчид, нийслэлийн

иргэддээ толилууллаа.

“НИЙСЛЭЛ ХҮРЭЭ 100 ЖИЛ” ном хурах ажиллагаа

Соёлын төв өргөөний их танхимд Зүүн хүрээ Дашчойлин хийдийн хамба лам, лам нарын хамтаар хуран цулгасан сүсэгтэн олонд зориулж ном айлдаж, Халхын анхдугаар богд Занабазарын зохиосон “Жинлавцогзолмаа” судрыг айлдлаа. Хуран цугласан нийслэлийн удирдлагууд, төр захиргааны байгууллагын ажилтан албан хаагчид, иргэдэд эдийн дээд хадаг, арц, буудай тэргүүтнээр номын авшиг хүртээлээ.

“Улаанбаатар хотын түүхэн дурсгалуудтай танилцах аялал”

Ширээт Цагаан нуурын хөвөөнд 373 жилийн тэртээ Өргөө нэртэйгээр үүссэн

өнөөгийн Улаанбаатар хот 100 жилийн өмнө буюу 1912 онд Олноо өргөгдсөн Монгол Улсын “Нийслэл хүрээ”-гээр өргөмжлөгдөж, тусгаар тогтнолын нэг баталгаа болсон билээ. Нийслэл хүрээний 100 жилийн ойн хүрээнд иргэд нэн ялангуяа хүүхэд, залууст хотын түүх, соёлыг сурталчлан таниулах, “нийслэл хот-нийслэлийн иргэн”-ээрээ бахархах, хайрлах сэтгэлтэй, соёлтой иргэнийг

төлөвшүүлэх зорилгоор “Хүрээ соёл” аяныг өрнүүлж байгаа бөгөөд тус аяны хүрээнд “Улаанбаатар хотын түүхэн дурсгалуудтай танилцах аялал”-ыг Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн соёл, урлагийн газар, Нийслэлийн хүүхдийн төлөө газар, Улаанбаатар хотын музей, дүүргүүдийн Засаг даргын тамгын газар хамтран төвийн зургаан дүүргийн төлөөлөл болсон хүүхдүүдийн дунд зохион байгууллаа.

“Улаанбаатар хотын түүхэн дурсгалуудтай танилцах аялал”-ын нээлт 2012

оны 4-р сарын 24-нд Соёлын төв өргөөний гадна талбайд болсон бөгөөд нээлтийн үйл ажиллагаанд Нийслэлийн Засаг даргын орлогч Ц.Цогзолмаа, Нийслэлийн соёл, урлагийн газрын дарга Ц.Пүрэвхүү, Нийслэлийн хүүхдийн төлөө газрын дарга С.Алтанцэцэг болон бусад албаны төлөөлөгчид, сэтгүүлчид, аялагч хүүхдүүд оролцлоо.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дээрх түүх, соёлындурсгалуудад түшиглэн Улаанбаатар хотын хөгжлийн явцад бүрэлдсэн бүтэц, зохионбайгуулалт, байршил, түүхэн дурсгалт газруудыг аяллын хөтөлбөрт тусгагдсан маршрутын дагуу хүүхдүүдэд танилцуулсан бөгөөд аяллын хөтчөөр Улаанбаатар хотын музейн эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяр явав.

Аялалын маршрутыг XX зууны эхэн үеийн Нийслэл хүрээний түүхэн байршил, нэр хийгээд өнөө ямар нэртэй газар болсныг сонирхуулан Гадаад харилцааны яамны арын цэцэрлэгт хүрээлэн /Хүн чулууны хонхор/ - Д.Сүхбаатарын талбай /*Зүүн хүрээ гучин аймгийн урдах гол чөлөө*/ - Улаанбаатар хотын музей /*Цогтбадамжавын байшин*/ - Консулын дэнж /*Консулын сайдын дэнж*/ - Амгаланбаатар /*Маймаа хот*/ - Зөвлөлтийн дайчдын дурсгалд зориулсан хөшөөний цогцолбор /*Зайсан толгой*/- Гандангийн дэнж /*Гандангийн дэнж*/ – Барилгачдын талбай /*Махан дов буюу Яргачны дов*/ – Д.Сүхбаатарын талбай /*Гол чөлөө*/ гэсэн маршрутаар 34,1 км аялалаа.

Дөрөвдүгээр сарын 23-наас 27-ны хооронд 5 хоног үргэлжилсэн уг аяллын эхний өдөр Баянзүрх дүүргийн 43-р сургуулийн сурагчид, хоёр дах өдөр Чингэлтэй дүүргийн 5-р сургууль, Баянгол дүүргийн 38 дугаар сургуулийн сурагчид, гурав дах өдөр Сүхбаатар дүүргийн “Гэгээрэл” төвийн хүүхдүүд, дөрөв дэх өдөр Хан-Уул дүүргийн хороо бүрээс сонгогдсон хүүхдүүд, тав дах өдөр Сонгинохайрхан дүүргийн 76-р сургуулийн сурагчид нийт 180 хүүхэд аялалд хамрагдлаа.

Мөн энэхүү аялалын үргэлжлэл болгон 2012 оны 05 дугаар сарын 11-ны өдөр Чингэлтэй дүүргийн 103-р цэцэрлэгийн төгсөх ангийн 100 хүүхдийг зохион байгуулж аялууллаа.

Хүрээ нүүдэл хийгээд өндөр гэгээн Занабазарын амьдрал,үйл хэрэгтэйхолбогдсон газраар аялсан тухай

Нийслэл хүрээ – 100 жил, “Хүрээ соёл” аяны хүрээнд Өргөө, Их хүрээний нүүдэллэн суурьшиж байсан газрууд болон Монголын шарын шашны анхдугаар богд өндөр гэгээн Занабазарын амьдрал, уран бүтээл, үйл хэрэгтэй холбогдолтой газруудаар Чингис хаан дээд сургуулийн багш, газарзүйч О.Сүхбаатараар ахлуулсан нийслэлийн Соёл, урлагийн газар, нийслэлийн Аялал жуулчлалын газар, Улаанбаатар хотын музей зэрэг байгууллагуудын төлөөлөл бүхий бүрэлдэхүүнтэй баг 2012 оны 7-р сарын 20-ноос 30-ны хооронд буюу 10 шөнө,

Нийслэлийн Соёл урлагийн газар

11 хоногийн аялалыг амжилттай зохион байгууллаа. Тус аялалаар Төв, Өвөрхангай, Архангай гэсэн гурван аймгийн нутаг дамнасан Өргөө, Их хүрээ нүүдэллэн суурьшсан 6 газарт босгосон дурсгалын хөшөөний хадгалалт хамгаалалтын байдалд үзлэг хийж, өндөр гэгээн Занабазарын амьдрал, үйл хэрэгтэй холбогдолтой газруудтай танилцаж, тус түүхэн дурсгалт газруудыг аялал жуулчлалын бие даасан бүтээгдэхүүн болгож, маршрутад оруулах боломжийг судласнаараа онцлог бүхий цогц аялал боллоо.

Их хүрээ 1732-1733 онд Бургалтайн голд суурьшиж байсан бөгөөд яг үүгээр Хиагт орох худалдааны зам дайрч Хятад худалдаачид явуулын хүмүүс олноор сүлжилдэх болсон тул Хүрээг олны хөлөөс холдуулж нүүлгэжээ.*Хөшөөний хадгалалт хамгаалалт:* Дурсгалын хөшөөний гадуур модон дөрвөлжин хашаа хийж хамгаалжээ. Хөшөөний дээд тал дахь Хүрээ нь суурин газрын шинжтэй болж эхэлжээ.Хөшөөний урд болон хойд талын хэд хэдэн хэсэгт чулуу үйрч, бичээс нь бүдгэрсэн. Сэрэг модтой.

Занабазарын төрсөн газар, түүний бүтээсэн суварга: Өндөр гэгээн хэмээн олноо алдаршсан Занабазар нь 1635 онд өнөөгийн Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын нутагт Халх Монголын Түшээт хан Гомбодоржийн дэд хөвгүүн болон мэндэлжээ. Тэрээр 1639 онд Халх монгол шарын шашны тэргүүн анхдугаар богдоор өргөмжлөгдөж, улмаар монголын улс төр, урлаг соёлын томоохон зүтгэлтэн болсон юм. Тус аялалын хүрээнд дээрх түүхэн дурсгалт газруудыг жуулчдын зорин үзэх газар болгож аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгох зорилгоор тэдгээр газруудын ойролцоох байгаль, түүхийн дурсгалт газруудыг тогтоож, аялалын шинэ хөтөлбөр боловсруулах судалгааны ажлыг хийсэн.

Өвөрмонголд болсон “Тал нутгийн соёлын өдрүүд” арга хэмжээнд соёлын ажилтан, уран бүтээлчид 35 хүнийг оролцуулж, “Аравт” киноны нээлтийг хийж, соёлын хамтын ажиллагааны асуудлаар ярилцлага хийлээ.

Их монгол улс байгуулагдсаны 806, Ардын хувьсгалын 91 жилийн ойн их баяр наадмын соёл урлагийн үйл

ажиллагаануудыг амжилттай зохион байгуулав. Үүнд:Баяр наадмын Хүндэтгэлийн концертыг 07 сарын 10-ны өдөр зохион байгуулсан бөгөөд уг концертод ҮДБЭЧуулгын Н.Ганболд, С.Баярбаатар нарын бүрэлдэхүүнтэй найруулагчийн баг, мэргэжлийн урлагийн байгууллагуудын 1000 орчим уран бүтээлчдийг хамруулж, удирдлага, зөвлөмжөөр хангаж ажилласан бөгөөд хүндэтгэлийн тоглолтыг Монгол улсын Ерөнхийлөгч, гадаад, дотоодын зочид төлөөлөгчид, наадамчид өндрөөр үнэллээ.

Үндэсний их баяр наадмын нээлт болон хаалтын ажиллагааг мэргэжлийн уран бүтээлчид, урлаг, соёлын байгууллагыг татан оролцуулж, төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу бэлтгэлийг ханган МУ-ын УГЗ Ц.Ганхуягийн найруулгаар 07 дугаар сарын 11-ны өдөр Төв цэнгэлдэх хүрээлэнд амжилттай зохион байгуулж наадамчин олноо баясан цэнгүүлэв.

Total music, MCS компанитай хамтран “Улаанбаатарын үдэш” цэнгүүнийг 07 дугаар сарын 11-ний өдөр бэлтгэлийг ханган амжилттай зохион байгуулсан. Цэнгүүнд шинэ залуу нэрд гарч буй хамтлаг дуучид, уран бүтээлчид оролцсон нь төв талбайд хуран цугласан олны талархалыг хүлээсэн ажил боллоо.

Баяр наадмын үеэр Монгол улсын Ерөнхийлөгчийн Төрийн хүндэтгэл, ёслолын дайллагын урлагийн тоглолт, уран бүтээлчдийн бэлтгэлийг хөтөлбөрийн дагуу зохион байгууллаа. Наадмын өдөр Монголын Уран зургийн галлерейтэй хамтран “Монголын сайхан орноор” уран зургийн үзэсгэлэнг нээлээ.

07 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд Монголын Урлагийн зөвлөлтэй хамтран Хүй долоон худагт “Соёлын наадам”-ыг 5 дахь жилдээ хамтран амжилттай зохион байгуулж, наадмын комиссоос баталсан соёл, урлагийн хөтөлбөрийн дагуу наадамчин олондоо соёлын үйлчилгээг баярын өдрүүдэд хүргэлээ.

Нийслэл хотын 373 жилийн ойн өдөрт зориулан Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Дагвын Лувсаншаравын нэрэмжит Хүүхдийн

найрал дууны уралдаан 20 дахь жилийнхээ ойг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн ивээл дор “Хүүхдийн найрал дууны наадам” болгон зохион байгуулснаар нийслэлийн дүүргүүдийн 90 гаруй ЕБС-ийн 1350 гаруй найрал дууны хүүхдүүд оролцож, 100 гаруй дуу хөгжмийн багш нар, 30 гаруй соёл урлагийн ажилтан уран бүтээлчид хамтран ажиллалаа.

Наадамд ЕБС-иудаас гадна Монголын Хүүхдийн ордон, Нийслэлийн 42-р цэцэрлэгийн багачууд, “Лоолойгийн найзууд”, Дархан-Уул аймгийн хүүхдийн найрал дууны “Хүслийн шувуухай” хамтлаг, “Монгол эгшиглэн”, “Яруу эгшиглэн” зэрэг хамтлагууд наадамд оролцлоо.

Наадмын үеэр МУ-ын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин, Хөгжмийн зохиолч, нэрт хормейстр Дагвын Лувсаншаравт Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Баттулга, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл нар хүндэтгэл үзүүллээ.

Нийслэл хотын 373 жилийн төрсөн өдөрт зориулсан “Нийслэлдээ өргөх багачуудын дуу” хүүхдийн найрал дууны наадмын тоглолтонд оролцсонхүүхдүүдүзэгч олны хайр таархлыг хүлээж нийслэлийнхээ ойд бэлэг барилаа.

Тоглолтонд 1950-аад оноос хойш зохиогдсон Монголын хөгжмийн зохиолчдын үе үеийн бүтээлүүдээс толилуулж, НИТХ-ын дарга Д.Баттулга, Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл болон Нийслэлийн Засаг даргын орлогч дарга нар, агентлаг, харъяа байгууллага, алба хэлтэс, сургуулийн удирдлагууд, иргэд, эцэг, эх, сурагчдын төлөөлөл, НСУГ-ын харъяа байгууллагуудын удирдлагууд, мэргэжлийн уран бүтээлчид үзэж сонирхлоо.

Наадмын концертонд “хүүхдийн дууны” хэмээн алдаршсан МУГЖ В.Долгор, “Маамуу нааш ир”, “Арав гэж юу вэ” дуунууд, Улсын филармоний дуучин СТА С.Баттулга “Тагтаа” зэрэг

сэтгэлд хоногшсон дуунуудаа өргөж, хамтран тоглов.

Найрал дууны наадамд зориулан Монголын Хүүхдийн ордон “Ардын дууны эвлүүлэг”, СБД-ийн 42-р цэцэрлэгийн багачууд “Хүүхдийн дууны эвлүүлэг”, ЧД-ийн 5-р сургууль “Бид Буянт нутгийн үрс” зэрэг шинээр буюу шинэчилж найруулсан дууны 40 бүтээл тайзнаа эгшиглэлээ.

Нийслэл хотын төрсөн өдөр, Хүүхдийн найрал дууны 20 жилийг тохиолдуулан хөгжим судлаач, хормейстр, Хүүхдийн найрал дууны уралдаанд 19 жил шүүгчээр ажилласан Ч.Буянхишигийг Нийслэлийн дээд шагнал “Хангарьд” одон, “Оюуныундраа” цогцолборын багш Г.Даваацэрэнг “Нийслэлийн Хүндэт тэмдэг”-ээр тус шагнав.

НСУГ-нь төвөөс алслагдсан дүүргийн иргэдэд орчин үеийн программ хангамж бүхий номын сангийн үйлчилгээг ойртуулах зорилгоор Налайх, Багануур, Багахангай дүүргүүдийн соёлын ордны уншлагын танхим, номын каталогийг цахим хэлбэрт шилжүүлж коха сүлжээг холболоо. Тус газрын номын сан хариуцсан мэргэжилтэн, Хотын төв номын сангийн мэдээлэл технологийн ажилтан, каталогчийн ажлын баг дээрхи дүүргийн номын санчдад сургалт зохион байгуулж, тухайн дүүргийн иргэд орон зай харгалзалгүйгээр хэрэгцээт номоо интернетээр дамжуулан хайх, захиалах бүрэн боломжтой боллоо.

Нийслэлийн иргэдийн соёлын эрэлт хэрэгцээнд нийцсэн соёлын олон талт үйл ажиллагааг шинэлэг хэлбэрээр зохион байгуулах бодлого бариимтлан, Нийслэлийн дүүргүүдийн Соёлын ордон, Улаанбаатар хотын Номын сан, музей, Улаанбаатар чуулга, Соёлын төв өргөө болон кино театруудыг удирдлага, үйл ажиллагаагаар ханган, ажлыг нь тогтмол дүгнэж ажиллав.

НСУГ-аас 2012 оныг “Өрхийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан ялангуяа алслагдсан дүүрэг, хороодын иргэд, айл өрхөд соёлын үйлчилгээг ойртуулах, чанартай хүргэхэд онцгой анхаарч, дүүргүүдийн соёлын ордоны ажлыг шинэ шатанд гаргах, эрх зүй орчныг нь бүрдүүлэх, мэргэжлийн удирдлага, зөвлөмжөөр тогтмол хангаж ажиллалаа.

Дүүргүүдийн Соёлын ордоны соёл, урлагийн үйлчилгээний үндсэн чиглэл нь иргэдийг соён гэгээрүүлэх, нийтээрээ соёлжих яриа таниулга хийх, иргэдийн авъяас билгийг хөгжүүлэх, амралт чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэхэд соёлын үйлчилгээг хүргэж ажилласан байна.

Мөн Соёлын ордоны тайз, танхимаар авъяас чадвар сорьсон дуу, бүжиг, үндэсний болоод орчин үеийн урлагийн уралдаан, наадам, соён гэгээрүүлэх гэх мэт 620 гаруй ажлыг зохион байгуулж, өсвөр үе, иргэдийн авъяасыг хөгжүүлэх 28 төрлийн сургалтанд 1620 хүнийг хамруулан сургаж, төгсөлтийн гэрчилгээ олгож, тайлан тоглолтыг нь дүүргийн иргэд, эцэг, эх, найз, хамт олонд нь сонирхуулсан байна.

НИЙСЛЭЛИЙН “СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨДӨЛГӨӨНТ ТӨВ”

Энэ онд нийт 32 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулж давхардсан тоогоор 160 гаруй мянган иргэдэд үйлчилжээ.

СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨ

2012 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр 7 бүтээгдэхүүнээ 100% биелүүлж, удаагийн урлагийн тоглолт, хошин шог, үзвэрээр 460.000 гаруй үзэгчдэд үйлчилсэн бөгөөд тоглолтын өмнөх бэлтгэлийг сайтар ханган, соёлтой орчинд тохитой үйлчилгээг хүргэж ажиллалаа.

УБ ХОТЫН МУЗЕЙ

Тайлант хугацаанд музейгээс иргэдийг соён гэгээрүүлэх, мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулсан бөгөөд эдгээр ажил, үйлчилгээг “Нийслэл хүрээ 100 жил”, “Хүрээ соёл” аяны хүрээнд зохион байгуулснаараа онцлог юм. Үүнд:

Гэрэл зургийн үзэсгэлэн: Улаанбаатар хотын музей нь 2012 он гарсаар түүхэн тэмдэглэлт үйл явдал, цаг үеийн холбогдолтой “Нийслэл хүрээ 100 жил” (II/06 - II/19), “Хүрээ гангачуул” (II/20 - III/28), “Монголын шог зургийн түүх” (III/31-IV/20), “Мартагдсан аялгуу буюу хойд Солонгосын тэмдэглэл”(IV/23 - IV/27), “Амьдралын өнгө-2”(V/04- V/14), “Зуун дамнасан зургууд” (V/18 - V/24), “Хотын хүний зураг” (V/28 – VI/08), “Элсэн цунами” (VI/17-VI/24), “Нийслэлийн аудитын газрын 90 жил” (IX/14-IX21), “Дурсамж 45” (IX/25 - X/01), “Халхын сүүлчийн хутагт” (X/05 - X/11), Шог зураач Б.Мөнхбатын “Цаг ирвээс” (X/12 - X/19),“Нийслэл хүрээнээс Улаанбаатар” (X/26 – XI/25) гэсэн 13 гэрэл зургийн үзэсгэлэнг музейдээ зохион байгуулав. Мөн Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 373 жилийн ойн

арга хэмжээний хүрээнд хотын түүхэн хөгжлийг харуулсан явуулын гэрэл зургийн үзэсгэлэнг 5 өдөр, 5 өөр газар гаргасан бол Үндэсний архивын газартай хамтран Их тэнгэрийн аманд “1945 оны Монголын тусгаар тогтнолын төлөөх бүх нийтийн санал хураалт”, Их Майдар сантай хамтран Кемпинский зочид буудалд “Хүрээ майдар” сэдэвт явуулын гэрэл зургийн үзэсгэлэн гаргав. Тайлант хугацаанд музейд 13, явуулын байдлаар 3 нийт 16 үзэсгэлэн гаргаснаар тус музей түүхэндээ анх удаа нийслэл хотын хөгжлийн түүхийг харуулсан сэдэвчилсэн цуврал үзэсгэлэнгүүдийг дэлгэн үзүүлж, олон нийтийн хүртээл болголоо. Музейд зохион байгуулсан 13 үзэсгэлэнг 4960 хүн, явуулын гэрэл зургийн үзэсгэлэнг 12840 хүн нийт 17800 хүн үзэсгэлэн үзжээ.

Тус хугацаанд байнгын үзмэр, үзэсгэлэнгээр 8176, явуулын сурталчилгаагаар 12840, нийт 21016 хүнд үйлчилжээ. Музейгээр үйлчлүүлэгчдийн 4420 буюу 54,1 хувь нь том хүн, 1117 буюу 16,7 хувь нь оюутан, 2406 буюу 29,4 хувь нь хүүхэд, 233 буюу 2,8 хувь нь гадаадын жуулчид байлаа. Байнгын үзмэр, үзэсгэлэнгээр үйлчлүүлэгчдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулвал 16,1 хувиар, явуулын сурталчилгаагаар үйлчлүүлэгчдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6,7 дахин өссөн үзүүлэлттэй байна.

НСУГ, Улаанбаатар хотын музей, УБ хотын төв номын сан нь Ажлаа танилцуулах өдрийг 2012 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Баянзүрх дүүргийн 23 дугаар хорооны Улиастайн соёлын танхимд зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр иргэдэд явуулын номын сангаар үйлчилж, 32 иргэдийг номын сангийн уншигчаар бүртгэж, Улаанбаатар хотын түүх, шинэчлэн байгуулалттай холбоотой музейн үзмэр, ховор зураг дэлгэн үзүүлэхийн зэрэгцээ XX зууны эхэн үеийн Улаанбаатар хотын түүхийн талаар ярилцлага хийн, их бүтээн байгуулалттай холбоотой баримтат киног гарган иргэдэд соёлын үйлчилгээг үзүүллээ.

Тус музейгээс Улаанбаатар хотын түүх, соёлыг иргэдэд сурталчлах, тэдгээрийн мэдлэгийг өргөжүүлэх зорилго бүхий “Музейн Хөдөлгөөнт сурталчилгааны өдөрлөг”-ийг 7 газар зохион байгуулж, 1591 хүнийг хамруулсан.

Нийслэлийн түүх, үл хөдлөх дурсгал, музейн үзмэр, үйл ажиллагааны талаар 17 телевизээр 31 удаа, 4 сонин сэтгүүлээр 6 удаа, 2 радиогоор 7 удаа нийт 23 хэвлэл мэдээллийн хэрэгслээр 44 удаа мэдээ, нэвтрүүлэг дамжуулж, иргэдэд мэдээлэл сурталчилгаа хийв.

УБ ХОТЫН ТӨВ НОМЫН САН

Монгол улсын Засгийн газар, Нийслэлийн төр захиргааны байгууллагын “Иргэдийн оролцоо-Өрхийн хөгжлийг дэмжихжил” зорилтыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж номын сангаас 2012 оныг “Иргэдийн уншлагыг дэмжих жил” болгон жил, улирлын төлөвлөгөөндөө тусган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж ирлээ. Үүнд:

1. Хан-Уул дүүргийн салбар номын санд УИХ-ын гишүүн Л.Болдын санаачлага дэмжлэгтэйгээр 135 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тохижуулан **“Хүүхэд залуучуудын хөгжлийн төв”-**ийг байгуулаа.

2. Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн уншигч хэрэглэгчид, болон монголын нийт иргэд олон нийтэд зориулан сургалт, мэдээлэл сурталчилгаа соёл-танин мэдэхүйн ажил болон бүх нийтийг хамарсан арга хэмжээ, хөтөлбөрүүдийг зохион байгуулах орчин үеийн мэдээллийн технологид суурилсан, ая тухтай орчинг бүрдүүлсэн зориулалтын “**АСМТ-ийн Хөтөлбөрийн өрөө-Иргэдийн мэдээлэл сурталчилгааны танхим”-**ыг нээсэн. Энэхүү танхимыг байгуулахад АНУ-ын элчин сайдын яамнаас 115 мянган ам. долларын санхүүжилт хийсэн байна.

3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар **“Номын баярын өдөр тэмдэглэх”** болсонтой холбогдуулан анх удаа төрийн болон ТББ, олон нийтийн байгууллагаас хамтран “Олуулаа уншъя” уриан дор зохион байгуулсан өргөн хүрээтэй арга хэмжээнд номын сангаас тусгай хөтөлбөр гарган оролцжээ. Үүнд:

- Төв болон салбар номын сангуудынүйл ажиллагаа, шинэлэг үйлчилгээнүүдийг иргэд олон түмэнд нээлттэй танилцуулж, тэднийг номын сангийн уншигчаар бүртгэж номын сан номзүйн үйлчилгээнд хамруулж хэрэгцээт мэдээллээ олж авахад дэмжлэг үзүүллээ.
- Хүүхэд, залуучууд, иргэдийн дунд өөрийн номын сангийн сан хөмрөгт байгаа хэвлэмэл болон брайль, ярьдаг, дижитал буюу тоон технологид суурилсан монгол болон гадаад ном хэвлэлийн үзэсгэлэн гаргаж, ном солилцох, хандивлах, арга хэмжээг зохион байгуулсан.
- Шилдэг ном шалгаруулах, номын зохиогчийг алдаршуулах, “Тэргүүний уншигч-Д.Нацагдорж” тэмдэгтэн шалгаруулах, зохиолч уншигчдын уулзалт ярилцлага хийсэн.
- Төв болон салбар номын сангийн хэмжээнд нийслэл хот үүсч байгуулагдсаны 373 жилийн ойг угтан нийслэлийн хүн амыг номын сангийн үйлчилгээнд хамруулах, номтой нөхөрлүүлэх зорилго бүхий

“Улаанбаатарчууд уншиж байна” сэдэвт сарын аяныг уламжлал ёсоор зохион явуулж, иргэдийн ном унших идэвх сонирхлыг өрнүүллээ. Аяны хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлалын яамнаас төв болон салбар номын сангуудад “Нүүдлийн номын сан ажиллуулах”-аар олгосон автомашинаар нийслэлийн төвөөс алслагдсан хороодын хэрэглэгчдэд үйлчилгээгээ ойртуулах үүднээс нүүдлийн номын сангийн үйлчилгээг Баянзүрх дүүргийн 20, 28 дугаар хороод болон 8 дугаар хорооны нутагт байрлах “Хүүхэд асрах төв”, Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 3 дугаар хороо, Зэвсэгт хүчний 150, 0151 дугаар анги, Сүхбаатар дүүргийн 15, 20, Чингэлтэй дүүргийн 16, Сонгинохайрхан дүүргийн 7 дугаар хороо, Хан-Уул дүүргийн 12, 13, 14 дүгээр хороо буюу Нисэх, Яармаг, Өлзийт хороололд хүргэж ажилласан байна. Нүүдлийн номын сангийн үйлчилгээ нь нийслэлийн хүн амд үзүүлэх номын сангийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна.

- Тус төвлөрсөн номын сан нь Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн тодорхой заалтуудын хүрээнд уншлага үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн, уншлага үйлчилгээний төлөвлөгөөт үзүүлэлтүүдийг 101,5%-120,4%-д хүргэн, жилийн төлөвлөгөөг 100%-иар ханган биелүүлсэн байна.
- 2012 онд доорх ном хэвлэлийг бүрдүүлэн авсан байна.

№	Бүрдүүлэлт	Нэр төрөл	Ширхэг	Үнэ
1	Шинэ ном	270	1868	23.972.800
2	Хандив	102	724	5.209.500
3	Бэлэг	153	427	1.957.350
4	Нөхөн бүрдүүлэлт	33	33	565.235
5	Алдагдсан номын төлбөр	16	16	62.701
Нийт дүн		574	3068	31.767.586

Өрхийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд тус номын сан үйлчилгээний үнэ тарифыг хямдруулж, төв болон салбар номын сангууд үйлчилгээндээ мөрдөх болсноор уншигч хэрэглэгчдийн тоо өссөн дүнтэй байна. Тухайлбал: Энэ оны уншлага үйлчилгээг өнгөрсөн 2011 оныхтой харьцуулбал дараах байдалтай байна.



Ном олгосон байдлыг авч үзвэл:



“Улаанбаатар цахим” хөтөлбөрийг хэрэгжүүлж, номын сангийн үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчлүүлэгчдийн мэдээлэл олж авах цар хүрээг өргөсгөх, номын сангаар үйлчлүүлж буй уншигч, иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор“Номын сангийн вэб систем, “цахим уншлага үйлчилгээ” төслийг 6 сарын хугацаанд 31500 ам долларын санхүүжилттэйгээр амжилттай хэрэгжүүллээ.

“УЛААНБААТАР” ЧУУЛГА

“Хүрээ хорвоо”, “Янзаган хүрээ”, “Гоолингоо” дуулалт жүжиг, “Мөрөөдлийн үзэг”хүүхдэд зориулсан жүжиг, “Миний эх орон” тоглолт гэх мэт 6 шинэ уран бүтээл тайзнаа тавьж, гоцлол дуучин МУГЖ Д.Ширмэнтуяа, Т.Баяраа зэрэг 8 уран бүтээлчийн уран бүтээлийн тайлан тоглолт, “Нийслэл хүрээ 100 жилийн ойн

хүндэдтгэлийн тоглолт, Дээлтэй Монгол наадам, их эзэн Чингис хааны мэндэлсэний 850 жилийн ойн “Монгол туургатан” язгуур урлагийн хүндэтгэлийн нэгдсэн тоглолтод уран бүтээлчдээ оролцуулан, нийслэлийн төр, захиргааны ёслол, хүндэтгэлийн удаа дараагийн үйл ажиллагаанд урлагийн тоглолт, соёлын үйлчилгээ үзүүлсэн байна. 2012 онд 113 удаагийн урлагийн тоглолт, захиалгат урлагийн үйлчилгээг 100.0 үзэгчдэд үзүүлсэн байна. НИТХ, НЗДТГ-ын 41, агентлагуудын 10 захиалгат тоглолтыг хийсэн байна.Тус чуулга нь Нийслэлийн Архивын газартай хамтран архив, албан хэрэг хөтлөлтийн ажлаа чанаржуулж, Нийслэлийн “Архивын загвар байгууллага” болох үзүүлэх сургалт, туршлага дэлгэрүүлэх ажил зохион байгууллаа.Нийслэлийн Засаг даргын 2012 оны А/24 дүгээр захирамжаар эрх нь шилжин ирсэн “Улаанбаатар” чуулгын театрын үзэгчдийн сандал,тайзны зориулалтын хулдаас, хөшиг, “Хангарьд” үндэсний хөгжмийн найралд цохиур хөгжмийн зэмсэг худалдан авах ажлын тендерээр 326,8 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүний хөрөнгө оруулалт хийлгэжээ.

Нийслэлийн дүүргүүдийн ЗДТГ-ын НХ-ийн Соёл урлаг, ТББ хариуцсан мэргэжилтнүүд

НЗД-ын Нийгмийн асуудал хариуцсан орлогчийн баталсан “Дүүргүүдийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн ажил дүгнэх шалгуур, үзүүлэлт” болон Нийслэл, дүүргийн нийгэм эдийн засгийн зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрт соёлын асуудлаар тусгагдсан зорилтуудыг нутаг дэвсгэрийнхээ онцлогтой уялдуулан хэрэгжүүлж, идэвхи санаачилга, үр бүтээлтэй ажиллалаа.

НСУГ-аас Тэнгис, Өргөө, Соёмбо кино театрын үйл ажиллагаатайтанилцаж, тус кино театруудын 128 ажилтан, ажиллагсдад “Соёлын тухай хууль”, “Садар самуунтай тэмцэх тухай хууль”, Соёл урлагийг хөгжүүлэх төрийн болоод нийслэлийн бодлого, авч хэрэгжүүлж байгаа ажлын мэдээлэл хийж, үйлчилгээний соёл, менежментийн асуудлаар ярилцлага зохион байгууллаа.

Соёлурлагийнгадаадхарилцаахамтынажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд:

- БНХАУ-ын Хөх хотын Эрээн хотод Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогчоор ахлуулсан хөрөнгө оруулалтын бэлтгэл ажлыг хангуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус газрын дарга оролцож Эрээн-Улаанбаатар хотууд цаашид соёлын талаар хамтран ажиллах “Санамж бичиг”-т гарын үсэг зурсан.

03 дугаар сард хөрөнгө оруулагчдын зөвлөлгөөн Улаанбаатар хотноо амжилттай болж өнгөрлөө.

- 2012 оны 3 дугаар сарын 9-19-ний өдөр АНУ-ын Лос Анжелас, Вашингтон хотод Нийслэлийн Засаг даргын нийгмийн асуудал хариуцсан орлогчоор ахлуулсан ажлын хэсэгт тус газрын дарга нийгмийн салбарын ажилтнуудын мэргэжил, мэдлэг дээшлүүлэх талаар гэрээ хийх, зохион байгуулалтын үйл ажиллагаанд нь оролцсон.
- БНСУ-ын Намъянжү хотод 1 жилийн гэрээгээр 30 гаруй уран бүтээлчдийг сонгон шалгаруулан явуулсан бөгөөд үндэсний соёл, урлагаа сурталчлах, мэргэжил, чадвараа дээшлүүлэн ажиллаж байна.
- “Хан-Уул” соёлын өдрийг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол, Эрээн хот, Зүүн сүнд хошуунд 2012 оны 05 дугаар сарын 21-29-ны өдөр зохион байгуулав. Соёлын өдрүүдэд 150 гаруй ардын авъяастнууд оролцуулж амжилттай зохион байгууллагдлаа.
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа хамтын ажиллагааны хэлтэстэй хамтран БНСУ-ын Сөүл хотноо жил бүр зохион байгуулагддаг “Хай Сөүл” урлагийн наадамд “Улаанбаатар” чуулгын 30 гаруй уран бүтээлчдийг оролцуулав.
- Сөүл хотын Хүний нөөцийн академиас зохион байгуулсан “Хотын соёлын бодлого” сэдэвт олон улсын сургалтанд соён гэгээрүүлэх асуудал хариуцсан мэргэжилтнийг хамрагдуулав.
- БНХАУ-ын Манжуур хотод 07 дугаар сарын 03-ны өдөр Олон улсын Аялал жуулчлалын баярын үйл ажиллагаанд тус газрын ахлах мэргэжилтэн оролцлоо.
- Нийслэл Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан олон улсын Архивчдын семинарт тус газрын бичиг хэргийн мэргэжилтэн, ажлын ур чадвараа дээшлүүллээ.
- БНХАУ-ын ӨМӨЗО-ны соёлын өдрүүдийг Улаанбаатар хотноо 09 дүгээр сарын 17-ноос 21-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулагдахад НСУГ хамтран ажиллаж, ӨМӨЗО-ны Хөх хотын өдрүүдэд зориулсан урлагийн тоглолтыг Соёлын төв өргөөнд зохион байгуулав.
- Мөн Улаанбаатар хот, Хөх хотын хамтын ажиллагааны уулзалтыг Монголын Үндэсний Худалдаа Аж үйлдвэрийн танхимд зохион байгуулж бизнес, соёлын салбарт хамтран ажиллах өргөн боломж нээгдлээ.

Нийслэлийн Соёл урлагийн газар 2005 оноос хойш БНХАУ-ын Манжуур хотын захиргаатай соёлынталаар хамтын ажиллагааны гэрээтэй ажиллаж Олон улсын гоо бүсгүй шалгаруулах тэмцээнийг жил бүр зохион байгуулж ажилласан

Энэ онд тус уралдаан 8 дахь удаагаа зохион байгуулагдаж Монгол улсаас 15 гоо бүсгүйг шалгаруулан бэлтгэж оролцуулсанаас 2,3 дугаар байрыгБНХАУ, ОХУ-ын бүсгүйчүүд, **Тэргүүн байр, Гуравдугаар** байрын шагналыг Монгол улсын гоо бүсгүй тус тус эзэлж амжилт гаргалаа.

Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах асуудлаар:

Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу 5 мэргэжилтэнд буцалтгүй тусламж, хүүхэд төрүүлсэн, шинээр гэр бүл болсон ажилтнуудад хамт олны баярын мэндчилгээ хүргэж, шинэ жил, хүүхдийн баяр, цагаан сар, ахмадын өдрөөр хүүхэд, ахмад ажилтнуудаа хүлээн авч, бэлэг дурсгалын бэлэг өгөх, урлаг, соёлын шинэ үзвэр үзүүлэх, ажилтнуудад орон нутагт амарсанунааны зардал, түлээ нүүрсний мөнгөн тусламж олголоо.

Ажилтнуудын ажлын байрны нөхцөлийг сайжруулахаар мэдээлэл, технологи, компьютер, техник тоноглолын сэлбэг, хэрэглэл, 5 офисс, өрөөний 19 цонхны туузан хөшгийг шинэчилж, сандал, ширээ, ус буцалгагч г.м 10 гаруй сая төгрөгийн эд хошил, албан хэрэгцээний зүйлээр хангалт хийлээ.

Төрийн албаны удирдлагын сургуулийн Нийгмийн удирдлагын гарагийн ангийн /2012-2014/ Засгийн газрын тэтгэлэгт сургалтанд тус газрын мэргэжилтэн М.Мөнхсайхан, ХУД-ийн Соёлын ордоны менежер Д.Отгонбаяр, Улаанбаатар хотын музейн эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяр нарыг тус тус суралцуулж байна.

Нийслэлийн Соёл урлагийн газраас 2012 онд ажилтан албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлж чийрэгжүүлэх, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн дараах ажлуудыг зохион байгуулж ажиллалаа.

- Нийслэлийн Биеийн тамир спортын газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газраас гаргасан “Ажлын байранд хийх дасгал”, “Биеэ тэтгэн чийрэгжүүлэх дасгал”-ын плакатуудыг харъяа байгууллагууд болон мэргэжилтнүүдийн өрөөнд тараан байршуулж дасгалуудыг өдөр бүр тогтмол хийж хэвшүүллээ.
- Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн нэгдэлтэй хамтран 2012 оны 4 дүгээр сард газрын мэргэжилтнүүдийг эрүүл мэндийн бүрэн шинжилгээнд хамруулж, хүн бүрт чиглэсэн зөвлөгөө өгүүлэв.

- Газрын мэргэжилтнүүд болон харъяа соёл урлагийн байгууллагуудын ажилтнуудыг 2 удаа эрүүл агаарт аялал бие чийрэгжүүлэлт хийж, төрөл бүрийн уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулсан. Үүнд нийт 150 гаруй ажилтан оролцлоо.

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН 2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ БАЙДАЛ

Шалгуур үзүүлэлтүүд	Гүйцэтгэл хувь
ЗГ-ын мөрийн хөтөлбөр,эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилт, хэрэгжилтийн хувь	**100.0**
Монгол улсын хууль, тогтоомж, НИТХТэргүүлэгчдийн хурлын тогтоол	**100.0**
Нийслэлийн Засаг даргын захирамжийн холбогдох заалтуудын хэрэгжилт	**100.0**
Тухайн жилийн нийгэм эдийн засгийн зорилтын холбогдох заалтын хэрэгжилт	**100.0**
Тухайн жилд нийслэлийн төр захиргааны байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхээр зохион байгуулсан ажил үр дүн	**100.0**
Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний хэрэгжилт	**100.0**
Тухайн байгууллагад хэрэгжиж байгаа үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилт	**100.0**
НЗ-аас даргаас цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлсэн байдал,үр дүн	**100.0**
Байгууллагын үйл ажиллагааг чадавхижуулах,ёс зүй, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, төрийн ажил үйлчилгээг ил тод шудрага, шуурхай болгохоор хийсэн ажил, үр дүн	**100.0**
Ажил үйлчилгээний талаар иргэдээс санал авсан байдал, иргэдээс өгсөн үнэлгээ, ажилдаа тусган хэрэгжүүлсэн нь	**100.0**
НЗД-ын сонгуулийн бүрэн эрхийн хугацааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, биелэлт	**100.0**
Мэдээлэл технологи, ил тод, нээлттэй байдлыг хэрэгжүүлж,	**100.0**

угтах үйлчилгээ, зэрэг иргэдэд хандсан ажил, үйлчилгээний ахиц, үр дүн	
Хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээний хүртээмж, нийтийн соёлыг дээшлүүлэх талаар хийсэн ажлын үр дүн	**100.0**
Түүх дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах, соёлын өвийн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт, ажлын үр дүн	**100.0**
Улсын чанартай уралдаан, наадамд уран бүтээлчид ардын авъяастнуудыг хамруулсан байдал, үр дүн	**100.0**
Соёл урлагийн ажилтны мэргэжил дээшлүүлэлт, давтан сургалтын байдал	**100.0**
Соёл урлагийг хөгжүүлэхээр хэрэгжүүлж буй Засгийн газар, Нийслэлийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт	**100.0**
Харъяа байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, иргэдэд үйлчлэх хүртээмжийг нэмэгдүүлэхээр хийсэн ажил, үр дүн	**100.0**
Дундаж үнэлгээ 70.0	
Тайлант оны төсөв төлөвлөгөөнд тусгагдаагүй шинээр санаачилж хиисэн бүтээлч ажил, үр дүн	**100.0**
Улирал, жилийн ажлын тайлан, мэдээний чанар, хугацаа	**100.0**
Иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, мэдэгдлийн шийдвэрлэлт	**100.0**
Төсвийг хэмнэлттэй, үр өгөөжтэй зарцуулах, төсвийн зардлыг бууруулах талаар гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилт	**100.0**
Архив, бичиг хэрэг, хариутай бичгийн шийдвэрлэлт	**100.0**
Дундаж үнэлгээ 10.0	
Иргэд, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ	**100.0**
Дундаж үнэлгээ 20.0	
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ	**100.0**

ХЯНАСАН:

ДАРГА Ц.ПҮРЭВХҮҮ

ТАЙЛАН ГАРГАСАН

МЭРГЭЖИЛТЭН: М.БААСАНДОРЖ